

БАТЛАВ:
ДЭД БҮТЦИЙН САЙД

Б. ЖИГЖИД

БАТЛАВ:
ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц. НЯМДОРЖ

2003 оны дугаар сарын-ны өдөр

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ БАГЦ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Мэдээллийн технологийн тухай хууль, түүнд нийцүүлэн Электрон хэлцлийн тухай, Электрон гарын үсгийн тухай, Электрон засаглалын тухай бие даасан хуулиудыг батлан гаргах дараахь хууль зүйн болон практик шаардлага гарч байна.

Хууль зүйн шаардлага:

1. Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал"-д мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар дараахь стратегийн зорилтыг дэвшүүлж, тэдгээрт нийцүүлэн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан:

1. Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчин бүрдүүлж, төлөвшүүлэх зорилтын хүрээнд үндэсний мэдээлэл, холбооны технологийн удирдлага, бодлого, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, төрийн мэдээллийг нээлттэй болгох, иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, электрон арилжааг хөгжүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орохоор;
2. Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд мэдээлэл, холбооны технологид тулгуурласан бүх төрлийн үйлчилгээг дэмжиж хөгжүүлэхээр;
3. Төрийн мэдээллийн тогтолцоог мэдээлэл, холбооны технологиор дэмжин хөгжүүлэх зорилтын хүрээнд төрийн удирдлагын хөгжлийн стратегийн чадавхийг мэдээллийн технологиор дэмжих, төрийн байгууллага хоорондын үр өгөөжтэй мэдээллийн харилцааг хөгжүүлэх, төрийн мэдээллийн сүлжээ, сан мэдээллийн эрэлт хайлтын тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэхээр;
4. Мэдээлэл, холбооны технологийн бизнесийг өргөжүүлж, өндөр үр ашигтай эдийн засгийн салбар болгох зорилтын хүрээнд татвар, гааль, даатгал, банк, санхүү зэрэг бизнесийн салбарын үйлчилгээг электрон хэлбэрт шилжүүлэхээр;
5. Эдийн засаг-бизнесийн үр ашигтай, шуурхай мэдээллийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд электрон арилжааг нэвтрүүлэх, интернетийг бизнес, санхүү, худалдааны мэдээлэл солилцох үндсэн хэрэгсэл болгохоор;
6. Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдээлэл, холбооны технологийг эрчимтэй нэвтрүүлэх зорилтын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэхэд электрон арилжааны хэлбэрийг өргөнөөр ашигладаг болохоор.

2. Засгийн газрын 2002 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги"-д нээлттэй засаглалыг хөгжүүлэх, засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, засаглалын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох үүднээс электрон засаглалд шилжих бэлтгэл ажлыг хийж дуусгах, төрийн мэдээллийн найдвартай дэд бүтцийг бий болгох, программ хангамжтай болох, төрийн мэдээллийн электрон сан байгуулах, мэдээллийн хадгалалт, урсгалыг электрон хэлбэрт оруулах загвар, журмыг боловсруулан нэвтрүүлэх, мэдээлэл, холбооны технологийн чиглэлээр хийгдэх ажил, үйлчилгээтэй (электрон засаглал, электрон арилжаа, электрон гүйлгээ, электрон гарын үсэг, интернэт хэрэглээ) уялдан гарч ирэх харилцааг тус салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн зохицуулах зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар тус тус заасан.

3. Засгийн газрын "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-т заасан бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх Засгийн газрын үйл

ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд мэдээллийн технологийг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Практик шаардлага:

1. "Харилцаа, холбооны тухай", "Патентийн тухай", "Зохиогчийн эрхийн тухай", "Засгийн газрын тухай", "Иргэний бүртгэлийн тухай", "Татварын тухай" зэрэг хуульд мэдээллийн технологид хамаарч болох зарим заалт тусгасан байдаг. Гэвч эдгээр хуульд тусгасан зохицуулалт нь хэт ерөнхий байгаа нь мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн шаардлагыг хангахгүй байгаа юм. Түүнчлэн мэдээллийн технологи, түүний хэрэглээтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсэн ойлголтыг хуульчлаагүйгээс дээрхи хуулиудын холбогдох заалтууд хэрэгжих боломжгүй байгаа болно.

2. Мэдээллийн технологийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар Дэлхийн банкны шугамаар зөвлөгөө өгч ажилласан Сингапурын "Rajan@Tann" зөвлөх компанийн мэргэжилтнүүд Монгол Улс мэдээллийн технологийн тухай бие даасан хууль батлан гаргах нь зүйтэй байх тухай дүгнэлт хийсэн.

3. Дэлхийн банкны "Хөгжлийн Гарц Сан" хөтөлбөрийн санхүүжилтээр "Монголын Хөгжлийн Гарц" төрийн бус байгууллагаас Монгол Улсын хөгжлийн бодлого, дэд бүтцийн хөгжлийн стратеги, мэдээлэл, холбооны салбарын бодлого, эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт зэрэг асуудлаар нийт 500 байгууллага, 1300 өрх, 350 хүний дунд явуулсан судалгаагаар электрон ажил үйлчилгээ, электрон худалдаа, электрон банкны үйлчилгээ эрхлэгчдэд хууль эрх зүйн орчин дутагдаж байгаа нь тогтоогдсон.

4. Монгол Улсад мэдээллийн технологийн салбарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, дотоодын хууль тогтоомжийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн Комиссоос батлан гаргасан загвар хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад орны хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Мэдээллийн технологийн тухай ерөнхий хуулийн төсөлд нийцүүлэн Электрон хэрэгсэл ашиглаж байгуулсан хэлцэл /Электрон хэлцэл/-ийн тухай, Электрон гарын үсгийн тухай, Электрон засаглалын тухай бие даасан хуулийн төслүүдийг боловсруулна.

Мэдээллийн технологийн ерөнхий хуулиар нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд мэдээллийн технологийг нэвтрүүлж хөгжүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрхийг тогтоож, электрон баримт бичиг, электрон мэдээллийг эрхзүйн хувьд хүчин төгөлдөр гэж тооцох, тэдгээрийг ашиглах эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна.

Аж ахуйн үйл ажиллагаанд электрон хэрэгсэл ашиглан хэлцэл /цаашид "электрон хэлцэл" гэх/-ийг хийх, электрон хэлцлийг бичгээр үйлдсэн энгийн хэлцэлтэй адилтган үзэх, электрон хэлцлийг баталгаажуулах, түүнд баталгаат электрон гарын үсгийг хэрэглэх, электрон хэлцэлд оролцогч талуудын эрх, үүрэг болон хариуцлагыг тогтоохтой холбогдсон харилцааг Электрон хэлцлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна. Мөн хууль тогтоомжоор улсын бүртгэлд бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлэхээр тогтоосноос бусад төрлийн гэрээг электрон хэлбэрээр хийж болохоор хуулийн төсөлд тусгана.

Электрон гарын үсгийн тухай хуулиар электрон гарын үсэг ашиглах, түүнийг баталгаатайд тооцох нөхцөл, журам болон электрон гарын үсэг баталгаажуулах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлно.

Электрон гарын үсэг гэж гарын үсэг зурагчийг тодорхойлох, электрон мэдээлэл, баримт бичгийг баталгаажуулахад ашиглагддаг электрон дүрс, тэмдэгт байхаар хуулийн төсөлд тодорхойлно.

Төрийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээг электрон хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэх, төрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах, төрийн мэдээллийн системийг ашиглах, төрийн байгууллага, хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг Электрон засаглалын тухай хуулиар зохицуулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

Мэдээллийн технологийн талаархи багц хуулийн төслүүд батлагдсанаар мэдээллийн технологийг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх бөгөөд Интернет эдийн засаг, Интернет банк, санхүүгийн үйлчилгээ, онлайн худалдаа, үйлчилгээ зэрэг мэдээллийн технологийн төрөл бүрийн хэрэглээ эрчимтэй хөгжих нөхцөл, боломж бүрднэ. "Forester Research" технологийн судалгааны

хүрээлэнгээс гаргасан судалгаагаар Интернет эдийн засгийн эргэлт 2003 онд 3,2 орчим триллион орчим ам. долларт хүрсэн нь дэлхийн худалдааны 2000 оны нийт орлогын 5%-тай тэнцсэн байна.

Төрийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгон төрөөс иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг электрон хэлбэрт шилжүүлэх нөхцлийг бүрдүүлснээр төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай, найдвартай байдлыг хангах нөхцөл бүрднэ. Одоогийн байгаа орон тоо, цалингийн фондод багтаан төрийн байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчний үйл ажиллагааг нэгтгэх, холбогдох зарим үйлчилгээг хувийн секторын аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлснээр дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

Электрон гарын үсгийн тухай, Электрон хэлцлийн тухай хуулийг батлан гаргаснаар электрон хэлцэл, электрон гарын үсгийг бичгээр үйлдсэн энгийн хэлцэл, ердийн гарын үсэгтэй адилтган ижил түвшинд үзэх нөхцөл бүрдэж тэдгээрийг үйл ажиллагаандаа ашиглах хэрэглээ нэмэгдсэнээр эдийн засгийн хэмнэлт гарна.

Мэдээллийн технологийн талаархи дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор орчин үеийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглан гүйцэтгэх олон улсын худалдааг өргөжүүлэх, түүнд дотоодын аж ахуйн нэгж оролцох өргөн боломж нээгдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Электрон гарын үсгийн тухай, Электрон хэлцлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд эдийн болон эдийн бус баялагтай холбоотой бүхий л харилцааг зохицуулах суурь хууль болох Иргэний хуульд электрон гарын үсэг ашиглах, электрон хэрэгсэл ашиглан гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

НҮБ-ын Олон улсын худалдааны эрхзүйн Комисс /ЮНСИТРАЛ/-оос батлан гаргасан Электрон арилжааны тухай загвар хуульд аливаа мэдээллийг цаасан дээр, эсхүл электрон хэрэгсэлд хадгалагдаж байгаагаас нь үл хамааран, ижил түвшинд үзэх зарчмыг тусгасан.

Иргэний хуулийн 42.2-т "Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно" зааснаар электрон хэрэгслээр дамжуулан хэлцэл байгуулахдаа электрон гарын үсэг ашиглах нь энгийн хэлбэртэй бичгийн хэлцэлд тавигдах шаардлагад нийцэх юм. Иймд Иргэний хуульд электрон гарын үсгийг тухайн этгээдийн энгийн гарын үсэгтэй адилтган үзэж болох талаар /42.3 дахь хэсэгт/, мөн гэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол гэрээний саналыг зөвшөөрснөө бичгээр үйлдсэн баримт бичигтэй адилтган үзэж болох электрон мэдээлэл мэдэгдэж болох талаар /196.1.2 дахь заалтад/ тус тус нэмэлт оруулахаар хуулийн төслийг боловсруулна.